



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 1/342


Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Ча Бунданг” эрүүл мэндийн төв хооронд 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081315

Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 07 сарын 16-ны өдрийн  
А/В/12 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ-ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| №  | Овог нэр                        | Харъяалал                   | Монгол Улсад ажиллах байгууллага | Хамтран ажиллах гадаадын байгууллага                         | Гэрчилгээний сери/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл              | Зөвшөөрлийн төрөл | Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа    |
|----|---------------------------------|-----------------------------|----------------------------------|--|--------------------------|--|-------------------|---------------------------------|
| 1. | Чан Бюч Чул<br>Chang Byung Chul | Бүгд Найрамдах Солонгос Улс | Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг    | Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ча Бунданг" эрүүл мэндийн төв | ГЭ0002385                | Цээжний ба зүрх судасны мэс засал судлал | Эмчлэх            | 2019.08.24-2019.08.31 /8 хоног/ |
| 2. | Пак Хан Ки<br>Park Han Ki       | Бүгд Найрамдах Солонгос Улс | Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг    | Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ча Бунданг" эрүүл мэндийн төв | ГЭ0002386                | Цээжний ба зүрх судасны мэс засал судлал | Эмчлэх            | 2019.08.24-2019.08.31 /8 хоног/ |